МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
http://www.mojha.gov.mn

2018.08.23 № 1-1/4157

танай ____________-ны №____________-т

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.АСРАЛТ ТАНАА

Танайхаас ирүүлсэн Гаалийн ерөнхий газрын даргын 2018 оны "Төлбөрийн хэмжээ тогтоох тухай" А/149 дүгээр тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3946 дугаарт бүртгэснийг мэдэгдье.

Ц.НЯМДОРЖ

08 2862

Doc.yam a5.2018

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 08 сарын 23-ны өдрийн 3986 дугаарт бүртгэв.

# ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 14 өдөр     Дугаар А/149     Улаанбаатар хот

## Төлбөрийн хэмжээ тогтоох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 15 дугаар зүйл, мөн хуулийн $271^1$ дүгээр зүйлийн $271^1$.1.1, $271^1$.1.2 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 8 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барааны экспорт импортын статистикийн мэдээлэл” эмхтгэл, статистикийн мэдээлэл лавлагаагаар үйлчлэхэд авах төлбөрийн хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Статистикийн хэлтэс /Б.Цэрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2013 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/114 дугаар тушаалаар батлагдсан “Статистикийн мэдээлэл, лавлагаа авах тухай хүсэлтийг шийдвэрлэх журам”, “Төлбөрийн хэмжээ тогтоох тухай” 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/127 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА Б.АСРАЛТ

МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БИЧИГ ХЭРЭГ
УХГ0035 25
ХОЛБАР ҮНЭМ
18 08 20

00.000744

Гаалийн ерөнхий газрын даргын
2018 оны 08 дугаар сарын 14-ны
өдрийн A/177 дугаар тушаалын
хавсралт

"Барааны экспорт импортын статистикийн мэдээлэл" эмхтгэл, статистикийн мэдээлэл лавлагаагаар үйлчлэхэд авах төлбөрийн хэмжээ

| № | Мэдээллийн төрөл | Хэмжих нэгж | Төлбөр /төг/ |
|---|---|---|---|
| 1 | Барааны экспорт импортын статистикийн мэдээлэл эмхтгэл<br>Хэвлэмэл байдлаар:<br>- Сар бүрээр<br>- Хагас жилийн, жилийн эцсийн | <br><br><br>ш<br>ш | <br><br><br>5000<br>10000 |
| 2 | Мэдээллийн сангаас гаргасан статистикийн мэдээлэл | А4-ийн 1 нүүр | 5000 |
| 3 | Лавлагаа /жагсаалтаар/ | А4-ийн 1 нүүр | 5000 |
| 4 | Цахим лавлагаа | | 0 |

МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БИЧИГ ХЭРЭГ
УХГ0035 25
ХУУЛБАР ҮНЭН
18 08 20